

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

LEGAL REGULATION OF ENFORCEMENT ACTIONS FOR COLLECTING PAYMENTS FROM LEGAL ENTITIES AND RELATED CHALLENGES



Ч.Урангоо

*ДХИС-ийн Сургалт судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Иргэний
шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч*

Товч утга: Энэхүү илтгэлд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын асуудлыг авч үзэв. Хуулийн этгээдийн ойлголт, үндсэн шинж чанар, санхүүгийн тайлангийн төрлүүд болон санхүүгийн тайланг судалж, хөрөнгийн эх үүсвэр санхүүжүүлсэн талаарх компаний эзэд хэр хэмжээгээр хөрөнгө оруулалсан эсэх, мөн компани байгуулагдсанаас эхлээд хуримтлагдсан ашигтай эсэх, алдагдалтай ажиллаж байгаа болон ажилласан эсэх, ашигтай байвал ашгаа хэрхэн яаж зарцуулсан алдагдалтай ажилласан байвал алдагдлаа хэрхэн нөхсөн, хичнээн хэмжээний өр төлбөртэй байгаа өр төлбөрөө хэдий хугацаагаар төлөж барагдуулах боломж, чадвартай байгааг харах боломжтой.

Өөрөөр хэлбэл төлбөрийн чадвар сайтай эсэхийг харах боломжтой бөгөөд хөрөнгө илрүүлэх арга зүйг товч тайлбарлав. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгарч буй практик хүндрэл, шийдвэр гүйцэтгэгчдийн мэдлэг чадвар дээшлүүлэх шаардлагын талаар санал дэвшүүлэв.

Түлхүүр үг: Хуулийн этгээд, төлбөр гаргуулах, шийдвэр гүйцэтгэх, санхүүгийн тайлан, хөрөнгө илрүүлэх

Abstract: This presentation addresses the legal regulation of enforcement actions for collecting payments from legal entities. It examines the concept of a legal entity, its main characteristics, various types of financial statements, and

analyzes the company's owners' level of capital investment and financing sources. It also explores whether the company has accumulated profits or operated at a loss since its establishment, how profits were utilized if profitable, or how losses were covered if operating at a loss, as well as the amount of debt, and the ability and timeline to repay the debt.

In other words, it assesses the entity's payment capacity and briefly explains the methodology for identifying assets. Additionally, the presentation proposes recommendations regarding practical difficulties faced during enforcement actions and the need to enhance the knowledge and skills of enforcement officers.

Key words: Legal entity, To collect payment, enforcement of decision, financial statement, asset identification

ҮНДСЭН ХЭСЭГ

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хуулийн этгээдээс төлбөр гаргуулах асуудал нь өргөн хүрээтэй, нарийн төвөгтэй ажиллагаа юм. Энэ асуудлыг зөв ойлгож, практикт үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хуулийн этгээдийн тухай ойлголт, түүний эрх зүйн байдлыг нарийвчлан судлах шаардлагатай.

“Хуулийн этгээд гэдэг бол хөрөнгө төвлөрүүлэх, аж үйлдвэрийг хөгжүүлэх явцад бий болсон ойлголт бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ” (Мөнхжаргал, 2009, хууд. 185) гэж заасан байдаг. Иргэний хуулийн 25.1-д хуулийн этгээдийн үндсэн шинжийг тодорхойлжээ (Амарсайхан, 2010, хууд. 156).

1. Өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй
 2. Өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж, үүрэг хүлээх чадвартай
 3. Үйл ажиллагаанаасаа үүсэх үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг
- (Амарсайхан, Иргэний хуулийн тайлбар, 2010, хууд. 156)

Өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй гэдэг нь: Хуулийн этгээдийн тусгайлсан хөрөнгө нь түүний оролцогчид болох үүсгэн байгуулагч гишүүдийн хувь хөрөнгөөс тусгаарлагдсан байдаг. “Хөрөнгө гэдэг нь эд

юмс, эд юмсын эрх, эд юмстай холбоотой үүрэг байх бөгөөд хуулийн этгээд нь өөрийн тусгайлсан хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй. Холбоо, шашны байгууллага, сан гэх мэт үүсгэн байгуулагч, гишүүн дэмжигчид нь тухайн хуулийн этгээдийн тусгайлсан хөрөнгийн хувьд хөрөнгийн аливаа эрхийг эдлэхгүй. Хуулийн этгээдийн тусгайлсан хөрөнгөө өөрөө өмчлөх эрх нь нээлттэй. Иймд хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч болон гишүүд нь өөрсдийн хувийн өмчийг хуулийн этгээдийн тусгайлсан хөрөнгөд оруулсан хөрөнгийн ногдох ашигтай ажиллах эрхгүй бөгөөд татан буугдсан тохиолдолд өөрт оногдсон хэсгээ буцааж авах зэрэг эрх эдлэхгүй, татан буугдахад үлдсэн хөрөнгийг тухайн хуулийн этгээдтэй ижил зорилго бүхий өөр хуулийн этгээдэд шилжүүлэх, тийм байгууллага байхгүй бол төрийн өмчид шилжүүлж болдог. Харин компани, нөхөрлөл зэрэг хуулийн этгээдийн гишүүд хөрөнгө оруулагчид нь тухайн хуулийн этгээдийн тусгайлсан хөрөнгийг удирдах этгээдэд эрх олгож, түүгээр дамжуулан өөрийн хүсэл зоригийг илэрхийлэн оролцдог, ногдол ашиг хүртдэг, татан буугдах үед нь үлдсэн хөрөнгөөс өөрт оногдох хэсгийг салган авах зэрэг эд хөрөнгийн эрх эдэлдэг гэдэг утгаараа тусгайлсан хөрөнгийн өмчлөгч нь гишүүн буюу хувь нийлүүлэгчид байна. Харин тухайн хуулийн этгээд нь тусгайлсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй байна”. (Мөнхжаргал, Иргэний эрх зүй, 2008, хууд. 87).

Өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж, үүрэг хүлээх чадвартай гэдэг нь: “Хуулийн этгээд өөрийн нэрийн өмнөөс иргэний эрх эдийн болон эдийн бус олж, үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл хуулийн этгээд нь өөрийн нэрээр бусад иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, түүнээс бий болох эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Мөн үйл ажиллагаа явуулж байхдаа бусдад гэм хор учруулсан бол ийнхүү гэм хор учруулснаас үүсэх үүргийг уг хуулийн этгээд хүлээнэ”. (Мөнхжаргал, Иргэний эрх зүй, 2008, хууд. 87).

Үйл ажиллагаанаасаа үүсэх үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг гэдэг нь: Хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаанаасаа бий болох үр дагавар, бусдын өмнө хүлээсэн үүргийг тусгайлсан хөрөнгөөрөө бие даан хариуцна. “Компаний тухай хуульд зааснаар түүний эрх бүхий албан тушаалтан хувийн ашиг сонирхлын үүднээс компанийн нэрийг ашиглан аж ахуй үйл ажиллагаа явуулсан, компанийн хувь нийлүүлэгч, зээлдүүлэгч болон бусад харилцагчдад хуурамч мэдээлэл өгсөн, нэгмэл сонирхол бүхий этгээд болохоо мэдэгдээгүй зэрэг тохиолдолд компани болон түүний хувь

нийлүүлэгч, үүрэг гүйцэтгүүлэгчдэд учруулсан хохиролыг өөрийн хөрөнгөөр хариуцна гэж заасан байдаг. Энэ тохиолдолд компани бусдын өмнө үүрэг хүлээж үр дагавар бий болоогүй учир компанийн нэрийг ашиглан үйл ажиллагаа явуулсан гэм буруутай этгээд өөрөө хариуцлага хүлээж байна” (Мөнхжаргал, Иргэний эрх зүй, 2008, хууд. 87).

“Мөн иргэний эрх зүйн хариуцлагыг бие даан хариуцах шинжтэй байна. Хуулийн этгээд бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол хууль, гэрээнд заасан анз, торгууль, алданыг өөрийн эд хөрөнгөөр хариуцах ёстой”. (Мөнхжаргал, Иргэний эрх зүй, 2008, хууд. 88). Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь зааглагдаагүй, уг шаардлагыг хувьцаа эзэмшигч биелүүлээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигч өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээлгэх үндэслэл үүснэ (ШГА, 2020, хууд. 28).

“Хуулийн этгээд нь эзэмшил, өмчлөлийн хөрөнгө болон гэрээ, хэлцлээс үүсэх хөрөнгийн шинжтэй шаардах эрхээс төлбөр гаргуулахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-д Төлбөр төлөгч хуулийн этгээдэд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц мөнгөн хөрөнгө байхгүй тохиолдолд уг хуулийн этгээдийн хөрөнгө хэний эзэмшилд байгаагаас үл хамааран дараахь хөрөнгийг хураан авах, худалдан борлуулах, төлбөрт суутгах ажиллагаа явуулна” (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017).

“Мөнгөн хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд шууд хэрэглэгдэхгүй бусад материал, үнэт зүйл;

Бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй хөрөнгийн эрх;

Бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэх эд шууд хамааралгүй үл хөдлөх хөрөнгө;

Бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамаарал бүхий хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, бараа, материал, бусад түүхий эд, техник, тоног төхөөрөмж, үнэт цаас зэргээс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулна”. (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017).

Төлбөр төлөгч хуулийн этгээдийн харилцах болон хадгаламжийн данс дах мөнгөн хөрөнгө, өмчлөлийн хөрөнгөгүй хүрэлцэхгүй тохиолдолд:

“Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ”. (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2011) Үүнийг санхүүгийн байдлын тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч гэж ангилна. Үүнээс хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө бол нэг буюу түүнээс дээш тайлант хугацаанд үйлвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, бусдад түрээслүүлж, зориулалт нь захиргаа байдлаар ашиглаж байгаа биет хөрөнгө нь үндсэн хөрөнгөд орно. Дээрх хөрөнгө эргэлтийн бус хөрөнгө бөгөөд хөрөнгийн шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах, биет бус хөрөнгө нь шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийн байдлаар ангилагдана. Үүнд:

Д/д	Биет хөрөнгө	Биет бус хөрөнгө
1	Барилга байгууламж	Зохиогчийн эрх
2	Машин, тоног төхөөрөмж	Компьютерийн програм хангамж
3	Тээврийн хэрэгсэл	Патент
4	Тавилга, эд хогшил	Барааны тэмдэг
5	Компьютер, бусад хэрэгсэл	
6	Бусад хөрөнгө	

“Санхүүгийн байдлын тайланд эздийн өмч нь аж ахуй нэгжийн өр төлбөрөө төлсний дараагаар үлдэх цэвэр хөрөнгийн хэмжээг эздийн өмч гэж үзнэ” (Мөнхжаргал, Иргэний эрх зүй, 2008, хууд. 88).

“Төлбөр төлөгч хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд түүний өмчлөлд хамаарах гүйлгээнээс, эсхүл гүйлгээнд оруулахыг хязгаарласнаас бусад хөрөнгөнөөс төлбөрийг суутгана. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө хаана, ямар зориулалтаар ашиглагдаж байгаа нь үл хамаарна” (Лхагваа, 1999, хууд. 66)

Төлбөр төлөгч хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа авах, өмчлөл, эзэмшилд нь үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө бүртгэлтэй эсэх лавлагаануудыг авч хөрөнгөгүй нь тогтоогдож хуулийн этгээдийн санхүүгийн тайланд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.4-т зааснаар үзлэг хийх шаардлага үүсдэг бөгөөд Санхүүгийн тайлан нь 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Санхүүгийн байдлын тайлан буюу баланс, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан.

Нэг. Санхүүгийн байдлын тайлан буюу баланснаас харах ёстой зүйлс:

-Тухайн компани хэр хэмжээний эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгөтэйг;

-Уг хөрөнгөө ямар эх үүсвэрээр санхүүжүүлсэнийг;

-Компаний эзэн компанидаа хэр хөрөнгө оруулалт хийсэн, компани нь байгуулагдсан цагаас эхлэн ямар хуримтлагдсан ашигтай, алдагдалтай ажилласаныг;

-Ашигтай ажилласан бол ашгаа хэрхэн зарцуулсаныг, алдагдалтай ажилласан бол алдагдлаа ямар эх үүсвэрээс нөхсөнийг мэдэх боломжтой.

-Хэр хэмжээний өр төлбөртэй, өр төлбөрөө хэдий хугацаанд төлөх чадвартайг харж болно. Өөрөөр хэлбэл төлбөрийн чадвар сайтай эсэхийг харах боломжтой.

Хоёр. Орлого үр дүнгийн тайлангаас харах ёстой зүйлс:

Тухайн тайлант хугацаанд ямар орлого, зардал болон ашигт ажиллагаатай ажилласаныг харна.

“Нийт дүнгээр нь орлого, зардал ашгийг гаргах амархан. Орлого үр дүнгийн тайланг дэлгэрэнгүй байдлаар гаргах тусам тухайн компаний ажиллагааг илүү таньж мэдэх боломжтой. Жишээ нь: Ямар ямар орлого олсон, тухайн орлогыг олохын тулд ямар ямар зардал гаргасан, орлого зардал бүрээс ямар ашиг олсон гэх мэт. Өөрөөр хэлбэл хэд хэдэн төрлийн орлого олдог компаний хувьд /ресторан, бар, зочид буудал г.м/ орлого зардал бүрийг тус тусад нь, сар сараар задалж харуулбал энэ нь үнэ цэнэтэй мэдээлэл болдог.

Хэрэв зарим орлого нь 100 төгрөг олохын тулд 100-гаас илүү төгрөгний зардал гаргаад байвал уг орлогыг зогсоох, эсвэл бүр нэмэгдүүлэх арга хэмжээ авна. Энэ арга хэмжээг авахын тулд орлогын тайланг нарийвчилж гаргах ёстой байдаг.

Дээр дурдсаны дагуу орлого олдог эх үүсвэр бүр дээр тус тусад нь орлого, зардал, ашигт ажиллагааг гаргахгүй бол аль орлого нь илүү үр

өгөөжөө өгч, аль нь үр өгөөжөө өгөхгүй байгааг мэдэх боломжгүй”. (сургалт, 2020)

Үүнээс болж тухайн компаний бизнес чухам юун дээр алдаад байгааг мэдэхэд хүндрэлтэй болдог.

Гурав. Өмчийн өөрчлөлтийн тайлангаас харах ёстой зүйлс:

Компаний эзэн компанидаа хэдэн төгрөгний хөрөнгө оруулалт хийснийг

Компани байгуулагдсан цагаас эхлэн хуримтлагдсан ашигтай, алдагдалтай ажилласаныг

Тайлант хугацаанд ямар ногдол ашиг зарласныг

Компанийн эзний цэвэр хөрөнгийг харах боломжтой.

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн мэдээллийг Санхүүгийн байдлын тайлангийн эзэмшигчдийн өмч гэсэн хэсгээс мөн харж болно.

Дөрөв. Мөнгөн гүйлгээний тайлангаас харах ёстой зүйлс:

Мөнгөн гүйлгээний тайлангаас байгууллага мөнгийг хэрхэн олж хэрхэн зарцуулсаныг харах боломжтой. Тухайлбал:

Үйл ажиллагааны орлогоороо үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлээд цаана нь нэмэх эсвэл хасах мөнгө үлдэж байгааг харна.

Нэмэх бол орлогоороо зардлаа санхүүжүүлж чадаж байна,

Хасах бол чадахгүй байна гэсэн үг Үүнийг *үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ* гэдэг.

“Эргэлтийн бус хөрөнгө зарсан дүнгээс эргэлтийн бус хөрөнгө авсан дүнг хасч цаана нь нэмэх эсвэл хасах мөнгө үлдэж байгааг харна. Нэмэх бол эргэлтийн бус хөрөнгөө бууруулсан байна, хасах бол эргэлтийн бус хөрөнгөө нэмэгдүүлсэн компанидаа хөрөнгө оруулалт хийсэн байна гэсэн үг. Үүнийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэдэг.

Зээлийн эх үүсвэрээс зээл төлөлт, ногдол ашигт олгосон мөнгийг хасч цаана нь нэмэх эсвэл хасах мөнгө үлдэж байгааг харна. Нэмэх бол зээлээр санхүүжилт хийсэн байна, өр төлбөр нэмэгдсэн байна. Хасах бол зээл төлөлт, ногдол ашигт төлсөн мөнгө их байна гэсэн үг”. Үүнийг *санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ* гэдэг (сургалт, 2020).

Дээрх 4 төрлийн санхүүгийн тайлангаас шийдвэр гүйцэтгэгч нь цаашид ямар төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах талаар мэдээлэл авах бөгөөд хөрөнгө илэрсэн тохиолдолд битүүмжлэх, барьцаалах, хураах, худалдан борлуулах зэрэг ажиллагааг явуулах боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хуулийн этгээдүүд санхүүгийн тайлангаа ирүүлдэггүй, эсэргүүцэл үзүүлдэг зэрэг хүндрэлүүд түгээмэл байдаг. Хэрэв санхүүгийн тайланд үзлэгээр хөрөнгө илрээгүй тохиолдолд компанийн эздийн өмч нь аж ахуйн нэгжийн өр төлбөрөө төлсний дараа үлдэх цэвэр хөрөнгийн хэмжээ юм.

“Иймд компани өр төлбөрт орсон тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93.4 болон Компанийн тухай хуулийн 9.5-д зааснаар компанийн өр төлбөрийг давхар хариуцна гэдэг нь компанид оруулсан хувь нийлүүлэгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь компанийн хөрөнгөд бүртгэгдэн, тайлан тэнцэлд тусгагдаж, түүний хувийн эд хөрөнгөөс зааглагдсан байх ёстой боловч ийнхүү зааглаагүй тохиолдолд компанийн төлбөрийг барагдуулахад хувь нийлүүлэгчийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь компанийн өөрийн хөрөнгөд тооцогдон түүгээр компанийн хүлээх хариуцлагыг нөхөн төлнө гэж ойлгоно гэж тодорхойлсон байх тул шийдвэр гүйцэтгэгч нь санхүүгийн тайлан блансад үзлэг хийж компаний хувь нийлүүлэгчийн хөрөнгө зааглагдсан, зааглагдаагүйг тодохойлж, төлбөр барагдуулах боломж үүсч байна гэж судлаачийн хувьд дүгнэж байна”. (хүрээлэн, Legalinfo.mn, 2025)

САНАЛ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93.4-т заасан ...төлбөр гаргуулах эсэх асуудлыг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ... гэсэн заалт нь ойлгомжгүй байна. Учир нь Компанийн тухай хуулийн 9.5-д ...хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол... өөрийн хөрөнгөөр өр төлбөрийг хариуцна гэж заасан байдаг. Практикт шийдвэр гүйцэтгэгч тус компанийн хөрөнгийг зааглагдсан эсэхийг тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Иймд дараах саналыг дэвшүүлж байна:

1. Сургалт болон гарын авлага боловсруулах: Шийдвэр гүйцэтгэгчийн санхүү, ялангуяа нягтлан бодох бүртгэлийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор мэргэшсэн сургалт, гарын авлага зайлшгүй шаардлагатай. Энэхүү гарын авлага нь хуулийн этгээдийн санхүүгийн тайлангуудыг хэрхэн задлан шинжлэх, төлбөр гаргуулахад шаардлагатай мэдээллийг хэрхэн олж авах талаар нарийвчилсан зааварчилгааг агуулсан байх ёстой. “Тухайлбал, санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан зэрэг тус бүрээс ямар мэдээллийг авах, тэдгээрийг хэрхэн хооронд нь уялдуулан дүгнэлт гаргах талаар тодорхойлж өгөх хэрэгтэй”. (<https://www.mongolbank.mn/mn/currency-rates>, 2024)

2. Хууль тогтоомжийн тодорхойлолтыг сайжруулах: “Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч болон хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын асуудлыг зохицуулсан хууль тогтоомж дахь зааглагдаагүй гэх ойлголтыг илүү тодорхой болгох шаардлагатай. Жишээлбэл, ямар тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хөрөнгө компанийн хөрөнгөөс зааглагдаагүй гэж үзэх, мөн үүнийг батлахын тулд ямар нотлох баримт шаардлагатайг хуульчлах хэрэгтэй”. (<https://shuukh.mn/>, 2025)

3. Мэдээллийн сан үүсгэх: Төлбөр төлөгч хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшлийн хөрөнгийн мэдээлэл болон санхүүгийн тайлангуудыг нэгдсэн санд төвлөрүүлж, шийдвэр гүйцэтгэгчдэд нэвтрэх боломжийг олгох хэрэгтэй. Энэ нь хөрөнгө илрүүлэх ажиллагааг хурдасгаж, үр дүнг нэмэгдүүлнэ.

4. Мэргэжлийн нягтлан бодогч эсвэл аудиторын дүгнэлт авах: Хүндрэлтэй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь мэргэжлийн нягтлан бодогч эсвэл аудиторын дүгнэлтийг авах эрхтэй байх зохицуулалтыг бий болгох нь зүйтэй. Энэ нь хуулийн этгээдийн санхүүгийн байдлыг үнэн зөвөөр тодорхойлж, хөрөнгийг илрүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Эх сурвалж

<https://shuukh.mn/> (2025).

<https://www.mongolbank.mn/mn/currency-rates>, 4 (2024).

Амарсайхан, Н. (2010). Иргэний хуулийн тайлбар. Улаанбаатар: Хэвлэх үйлдвэр.

Амарсайхан, Н. (2010). Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Улаанбаатар: Хэвлэх үйлдвэр.

- Лхагваа, А. (1999). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй.
- Мөнхжаргал, П. (2008). Иргэний эрх зүй. УБ.
- Мөнхжаргал, П. (2008). Иргэний эрх зүй. УБ.
- Мөнхжаргал, П. (2008). Иргэний эрх зүй. УБ.
- Мөнхжаргал, П. (2008). Иргэний эрх зүй. УБ.
- Мөнхжаргал, П. (2008, 6 6). Иргэний эрх зүй. УБ. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11191>
- Мөнхжаргал, П. (2009). Иргэний эрх зүй. Улаанбаатар: хэвлэх үйлвэр.
- сургалт, С. (2020, 09 09). Retrieved from https://www.magicgroup.mn/mn:https://www.magicgroup.mn/mn/magic-group/magic_choice.html
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 42 (10 2011). Retrieved from Эрх мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=310>
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 24 (6 2017).
- Төрийн мэдээлэл эмхэтгэл, 24 (6 2017).
- хүрээлэн, Х. з. (2025, 06 05). Legalinfo.mn. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=186>
- ШГА, Ш. (2020). Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчид зориулсан гарын авлага. Улаанбаатар.